

## **“Бэрх уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын протокол**

2013.04.30

Улаанбаатар хот

“Бэрх уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2013 оны 04 сарын 30-ны өдрийн 10 цаг 15 минутанд “БиДиСек” ХК-ийн хурлын өрөөнд эхлэв.

Хуралд: Тооллогын комиссын даргаар “БиДиСек” ХК-ийн О.Пүрэвдорж, тооллогын комиссын гишүүнээр А.Болормаа, Т.Отгонцэрэн нар оролцов.

“Бэрх уул” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Пүрэвбаатар нар болон

Хувьцаа эзэмшигч А.Сугар, Ч.Мягмарсүрэн, Д.Ихтөгөлдөр болон “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлж Ө.Даваасүрэн нар оролцож нийт ирц 99.66% хурал нээснийг мэдэгдэв.

---

Хуралд даргалагчаар Б.Мэндсайхан сонгогдов.

Хэлэлцсэн нь:

Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан танилцуулга хийв.

Б.Мэндсайхан – Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе! Өнөөдрийн хурлаар бид дараах 5 асуудлыг хэлэлцэнэ:

- ТУЗ-ын гишүүд томилох
- 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг батлах
- 2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах
- ТУЗ-ын 2013 оны төсөв батлах
- Хувьцааг хуваах

---

А.Сугар – Хувьцаа эзэмшигчдийг эзэмшиж буй хувьцааны хэмжээтэй нь хамт мэдээлж болох уу?

Б.Пүрэвбаатар – Хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцааны тоог зарлах шаардлагатай байх. Тооллогын комисс тоолж үзээд нийт 99.6%-ийн ирцтэй байгааг мэдээлсэн байгаа. Үүнд бичгээр саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг мөн оруулсан.

Б.Мэндсайхан – Хурлын дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудалдаа орьё. ТУЗ-ийн гишүүд томилох тухайд хурлын тараах материал дээр байгаа ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшиж буй 11 хүнд та бүхэн өөрсдийн саналаа өгөөрэй.

Дараагийн асуудал болох компанийн 2012 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Компанийн 2012 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

А.Сугар – Далд уурхай ажиллаж байгаа юу?

Б.Мэндсайхан – Ажиллахгүй байгаа. Далд уурхай гэдэг маань саяны хэлсэн Дэлгэрхааны уурхай шүү дээ.

“Бэрх уул” ХК-ийн нүүрсний салбар дээр л бодит материаллаг үйлдвэрлэл явагдаж байгаа. Жоншны салбар дээр тооцоололын ажил хийгдэж байна. Харин алтны хэсэг дээр хаалт хийгдэж байна.

Товчхон мэдээлэл бол ийм байна. Дээр нь нэмж хэлэхэд ордын хувьд бүрэн хамгаалалттай, орон нутгийн нинжа байхгүй. Өнөөдрийн байдлаар “Бэрх уул” ХК-д 45 хүн ажиллаж байгаа.

Санхүүгийн хувьд өнгөрсөн жилд 1,9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Учир нь нүүрсний уурхай орон нутгийн шинжтэй болохоор ашиг маш бага, компанийн үндсэн урсгал зардал болон Дэлгэрхааны ажлын төсөлд нэлээд мөнгө зарцуулж байгаа. Энэ алдагдал цаашдаа 1, 2 жил үргэлжилнэ. Улсын болон төсвийн шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөр байхгүй. НӨАТ-дээр жилийн эцсээр авлагатай гарсан, энэ нь бодит борлуулалт байхгүй, гаднаас тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн учраас ингэж гарч байгаа.

Б.Пүрэвбаатар – ТУЗ-ийн дарга өнөөдөр ирж чадсангүй. Компанийн ТУЗ-ийн хурал Улаанбаатар хотод тогтмол болдог. ТУЗ-ийн хурлаар томоохон худалдан авалт, аливаа шийдвэр гаргалт болон компанийн удирдлагын томилгоог хийдэг.

Өнгөрсөн оны 12 сарын 28-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хийсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос шаардлага тавьсан учир ТУЗ-ийн зарим хараат бус гишүүдийг сольсон.

Компанийн удирлагад гарсан өөрчлөлтийн хувьд компанийн ТУЗ-д Жимми Вайлдыг оруулсан байгаа. Жимми Вайлд нь 30-аад жил уул уурхайн салбарт ажилласан, туршлагатай хүн байгаа.

Санхүү эрхэлсэн захиралаар Жеймс Флорэсийг томилсон, аудит нягтлан бодох бүртгэлээр олон жил ажилласан хүн байгаа. Энэ бүтцээр ирэх жил ажиллана. Компанийн шинэ удирдлагын тухай хурлын дараа олон нийтийн хэрэгслээр бас мэдээллэх болно.

Энэхүү хурлын дараагаар ТУЗ-ийн хурал хуралдана. Мөн вэб сайт дээрээ аудитын тайлан болон тогтоолуудыг тавина.

Хурлаар хэлэлцэх дараагийн асуудал бол хувьцааг хуваах тухай байгаа. Нэг ширхэг хувьцааг хоёр ширхэг болгож хуваана. Ингэхдээ хороонд хүсэлт гаргаад, хороо

зөвшөөрсөн тохиолдолд батална. Ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо нэмэгдэж, эргэлтэнд эерэг өөрчлөлт орох боловуу гэж найдаж байна.

Ч.Мягмарсүрэн – Нэмж хувьцаа гаргах уу?

Б.Пүрэвбаатар – Ер нь цаашдаа гаргана. Хөрөнгө оруулалтын хэтийн төлөв байгаа. Одоогоор бид томоохон хувьцаа эзэмшигчдээсээ хөрвөх нөхцөлтэй зээл авч алдагдлаа нөхөж, мөн Дэлгэрхааны төсөлдөө зориулж байна. Нэмж хувьцаа гаргахдаа бид мэдэгдэх болно.

А.Сугар – Хувьцааг 2 хуваадаг шалтгаан нь юу вэ?

Б.Пүрэвбаатар – Хувьцааны хувьд дүрмийн сан хэмжээгээрээ өөрчлөгдөхгүй, харин эргэлтийг нэмэгдүүлнэ.

Ч.Мягмарсүрэн – Гадаад захирлын хувьд хэр чадвартай хүн бэ?

Б.Мэндсайхан – Миний бие хувьдаа туршлагатай салбарын хүмүүсийг авсандаа баяртай байгаа. Жишээ нь Жимми Вайлд нь 30 илүү жилийн ил болон далд уурхайд ажиллаж байсан түүхтэй хамгийн сүүлд гэхэд ОХУ-д ажиллаж байсан Монголын орчинд нийцэж ажиллах чадвартай гэж үзэж байгаа. Жим Флорес мөн адил арвин туршлагатай. Нөгөө талаас гадны захирал томилоход зардал өндөртэй байдаг тал бий. Үүнийг харгалзан үзээд Жим Флорэсийг “Шарын гол” ХК-д давхар ажиллуулах байдлаар шийдсэн. Ингэвэл зардал нь арай бага гарч байгаа.

А.Сугар – Хувьцаат компанийн мэдээлэл нээлттэй байдаг. Компанийн аудитын болон санхүүгийн тайланг хаанаас үзэж болох вэ?

Б.Мэндсайхан – Хөрөнгийн бирж болон манай компанийн вэб сайт дээр байгаа. Мөн бид олон улсын Earnst Young LLC-ээр аудитаа хийлгэж байгаа. Одоогоор аудитын тайлан арай хийгдэж дуусаагүй байгаа учир энэ удаагийн материал дээр ороогүй.

А.Сугар – Хувьцааг хуваалаа гээд хувь бол өөрчлөгдөхгүй. Төвлөрөл их байна, уг нь бол номоороо 75-80% нь төвлөрч болно, үлдсэн нь зах зээл дээр гарах ёстой.

Б.Мэндсайхан – Төвлөрөл байгаа нь үнэн. Бид үүнийг яваандаа нэмэлт хувьцаа гаргах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа. Нөгөө талаас энэ хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудал учир хязгаарлах боломжгүй юм. Цаашид хөрөнгө оруулалт хийгдэхэд энэ төвлөрөл хэвийн хэмжээндээ очих болно.

За ингээд манай өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлууд дууслаа. Та бүхэнд саналын хуудас тарааж өгсөн байгаа, саналаа өгнө үү.

Одоо хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар цуглуулж, хурлын дараа тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах ба гишүүдийг томилох болно.

О.Пүрэвдорж – Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

*Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Ё.Лхагважаргал санал хураалтын дүнг танилцуулсан ба компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Жеймс Пассин 11,11%, Б.Батбаатар 11,11%, Б.Мэндсайхан 11,11%, Жеймс Флорэс 11,11%, Д.Даянбилгүүн 11,11%, Жимми Вайлд 11,11% - ийн санал авч хараат гишүүдэд сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Б.Батхуяг 11,11%, Д.Нарангоо 11,11%, Б.Батмөнх 11,11%-ийн саналтайгаар сонгогдлоо.*

*Хурлаар хэлэлцсэн бусад 4 асуудлыг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн гэж мэдэгдлээ.*

Б.Мэндсайхан – Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолуудыг танилцуулав.

За ингээд өөр хэлэлцэх асуулт байхгүй бол компанийн 2013 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдэе!

Хурлын протокол хөтөлсөн

А.БОЛОРМАА